



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



**Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан
байгууллагууд хуулийг 95.5 хувьтай хэрэгжүүлж,
хуулийн 6.9, 8.1 дэх заалтуудын хэрэгжилт хангалтгүй
байна.**

АГУУЛГА

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар <u>Тайланг бэлтгэсэн:</u> Дарга, тэргүүлэх аудитор Л.Ламаачин Аудитын менежер Д.Гансүх Ахлах аудитор Ц.Отгонням Аудитор П.Хорлоосүрэн Ө.Ринчинмядаг П.Норпил Р.Цэрэндолгор 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323108 дугаарын утас, 70323253 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: (Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 402 тоот)	Товчилсон үгсийн жагсаалт Нийтлэг үндэслэл Бүлэг А. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна. А.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна. А.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна. Бүлэг Б. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байна. Б.1. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа Баянтээг ХК нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна. Б.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна. Б.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй бөгөөд мэдээллээ байршуулаагүй байна. Бүлэг В. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавьсан боловч сумдын ИТХурлын хяналт, өмнөх оны зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. В.1. Сумдын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 65 хувьтай хяналт тавьсан байна.
--	---

В.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагч хяналтыг хэрэгжүүлсэн байна.

В.3 Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудынхаа ажлыг дүгнэхдээ төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болгосон байна.

В.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Тайлан баталгаажуулсан тушаал

Албан шаардлага

Аудитын хавсралт маягт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
АЗЗА	Авто замын засвар, арчлалт
ХК	Хувьцаат компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
УБХэлтэс	Улсын Бүртгэлийн хэлтэс
БСУГГазар	Боловсрол соёл урлагийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БОАЖГазар	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу Өвөрхангай аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 -т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4 ,3.1.5 -д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

Аудитын хамрах хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5-д заасан хуулийн этгээд, төрийн байгууллага, албан тушаалтныг бүрэн хамруулан 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгав.

Үндсэн мэдээлэл:

Өвөрхангай аймгийн хэмжээнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 250 байгууллага хамрагдахаас 246 байгууллага мэдээллээ байршуулжээ. Төрийн чиг үүргийг гүйцэтгэгч Лхагва баасан, Жаргалант ирээдүйн мөрөөдөл цэцэрлэгүүд, Ахмадын хороо ТББ, Өв Эко Мийт ОНӨҮГазрууд шилэн дансанд бүртгэлгүй байна.

Аудитад хэрэглэсэн арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулганы дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитын стандартын талаарх мэдэгдэл:

Энэхүү аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан ҮАГ-НАГ/2018/01-НА аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын Нийцлийн аудитын багийн ахлах аудитор Ц.Отгонням, аудитор П.Хорлоосүрэн, Ө.Ринчинмядаг, П.Норпил, Р.Цэрэндолгор нар 2018 оны 10 дугаар сарын 24-өөс 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд хуулийг 95.5 хувьтай хэрэгжүүлж, хуулийн 6.9, 8.1 дэх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

БҮЛЭГ-А

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна.

А.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна.

Тус аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹, 3.1.2² заалтуудад хамаарах нийт төрийн өмчит 40, орон нутгийн өмчит 177; ОНӨААТҮГ, ОНӨҮГазар 22; ТӨҮГ, ТӨААТҮГазар 5 нийт 244 байгууллага шилэн дансны цахим системд бүрэн хамрагджээ. ӨВ ЭКО Мийт ОНӨҮГазар нь 2017 онд тус аймагт үйл ажиллагаа явуулж эхэлсэн, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэгдээгүй байна. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллүүдийг дээрх байгууллагууд хэрхэн байршуулсан байдлыг нэгтгэсэн тоон мэдээллээр үзүүлбэл.

Хүснэгт 1-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд мэдээлсэн байдал

Хуулийн хугацаа /жил бүр/		I/10		VIII/10		IV/25	IX/15
Шилэн дансны хуулийн заалт		6.1.1 Тухайн жилийн төсөв	6.1.1. ОНХС-ийн төлөвлөгөө	6.1.1. ХАА-ны төлөвлөгөө	6.1.2. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	6.1.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	6.1.3. Дараа жилийн төсвийн төсөл
3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд		244	244	244	244	244	244
Мэдээлсэн байдал	Тийм	207	19	100	229	230	191
	Үгүй	2	0	2	4	10	17
	Хугацаа хоцорсон	16	1	9	8	1	10
	Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй	19	224	133	3	3	26
	Тухайн мэдээллийг мэдээлсэн хувь	92.0	95.0	90.1	95.0	95.4	87.6

Хүснэгт 2-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд мэдээлсэн байдал үргэлжлэл

Хуулийн хугацаа /жил бүр/		VIII/15	IV/25		VII/01	Улирал бүр
Шилэн дансны хуулийн заалт		6.1.4. Санхүүгийн тайлан /хагас жил/	6.1.4. Санхүүгийн тайлан /жилийн эцсийн/	6.1.5. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	6.1.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	6.1.6. Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар
3.1.1, 3.1.2-д хамаарах байгууллагууд		244	244	244	244	244
Мэдээлсэн байдал	Тийм	208	214	175	153	188
	Үгүй	11	15	21	27	21
	Хугацаа хоцорсон	18	8	8	13	0
	Хамааралгүй буюу байхгүй, ажил гүйлгээ гараагүй	7	7	40	51	35

¹ 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

² 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар;

Тухайн мэдээллийг мэдээлсэн хувь	87.8	90.3	85.8	79.3	90.0
----------------------------------	------	------	------	------	------

Хүснэгт 3-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагуудаас мэдээлээгүй байгууллагын жагсаалт

№	Хуулийн заалт		Мэдээлэл оруулаагүй байгууллагууд
1	6.1.1 /жил бүрийн 01.10-ны дотор/	6.1.1 Тухайн жилийн төсөв	Арвайхээр сумын 10-р цэцэрлэг, Баруунбаян-Улаан сумын ИТХурал
2		6.1.1. ХАА-ны төлөвлөгөө	Зүүнбаян-Улаан сумын ЕБСургууль, Цэцэрлэг
3	6.1.2	6.1.2. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл /жил бүрийн 08.15-ны дотор/	Баянгол сумын Төрийн сан, Баруунбаян-Улаан, Богд, Нарийнтээл сумдын Эмийн эргэлтийн сангууд
4		6.1.2.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /жил бүрийн 04.25-ны дотор/	Бүрд сумын Эрүүл мэндийн төв, Есөнзүйл сумын Соёлын төв, Есөнзүйл сумын Цэцэрлэг, Өлзийт сумын Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Уянга сумын Жаргалант багийн сургууль, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Есөнзүйл, Хархорин сумдын Эмийн эргэлтийн сангууд
5	6.1.3. Дараа жилийн төсвийн төсөл /жил бүрийн 09.15-ны дотор/		Есөнзүйл сумын Эмнэлэг, Хархорин сумын ТЭДСан, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Есөнзүйл сумын Соёлын төв, Баянгол сумын ЕБСургууль, цэцэрлэг, Бүрд сумын Төрийн сан, Есөнзүйл сумын цэцэрлэг, Зүүнбаян-Улаан сумын ЕБСургууль, ЗДТГ газар, Цэцэрлэг, ИТХурал, Өлзийт сумын ЕБСургууль, Соёлын төв, Хайрхандулаан сумын ЕБСургууль, Соёлын төв
6	6.1.4	6.1.4. Хагас жилийн санхүүгийн тайлан /жил бүрийн 08.15-ны дотор/	Есөнзүйл сумын Сум дундын эмнэлэг, Хархорин сумын ТЭДСан, Баянгол сумын цэцэрлэг, Гучин-Ус сумын Соёлын төв, ЭМТөв, Өлзийт сумын ЕБСургууль, Соёлын төв, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Есөнзүйл сумдын ЭЭСан
7		6.1.4. Жилийн эцсийн санхүүгийн тайлан /жил бүрийн 04.25-ны дотор/	Есөнзүйл сумын Сум дундын эмнэлэг, Соёлын төв, Цэцэрлэг, Хархорин сумын спортын ордон, Гучин-Ус сумын ИТХурал, Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ, ИТХурал, Өлзийт сумын ЗДТГ, ИТХурал, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Есөнзүйл, Уянга, Хархорин сумдын ЭЭСан
8	6.1.5	6.1.5. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт /жил бүрийн 04.25-ны дотор/	Есөнзүйл сумын Сум дундын эмнэлэг, Хархорин сумын спортын ордон, Богд сумын Соёлын төв, Гучин-Ус сумын ЗДТГ, ИТХурал, Цэцэрлэг, Есөнзүйл сумын Соёлын төв, Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ, ИТХурал, Өлзийт сумын ИТХурал, Сант сумын ЭМТөв, Уянга сумын Жаргалант багийн бага сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Уянга сумын ЭМТөв, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Есөнзүйл, Уянга, Сант сумдын ЭЭСан
9		6.1.5. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /жил бүрийн 07.01-ний дотор/	Есөнзүйл сумын Сум дундын эмнэлэг, Хархорин сумын ТЭДСан, аймгийн Онцгой байдлын газар, Баянгол сумын ЕБСургууль, Богд сумын Соёлын төв, Цэцэрлэг, Бүрд сумын Соёлын төв, Цэцэрлэг, Гучин-Ус сумын ЗДТГ, ИТХурал, Есөнзүйл сумын Соёлын төв, Цэцэрлэг, Зүүнбаян-Улаан сумын ЗДТГ, ИТХурал, Цэцэрлэг, Өлзийт сумын ЕБСургууль, Соёлын төв, Сант сумын ЗДТГ, Уянга сумын ЗДТГ, ЕБ-ын 2-р сургууль, Хайрхандулаан сумын Соёлын төв, Бүрд, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Есөнзүйл, Уянга, Хархорин сумдын ЭЭСан
10	6.1.6. Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/		Есөнзүйл сумын Сум дундын эмнэлэг, Онцгой байдлын газар, Хархорин сумын Спортын ордон, Арвайхээр сумын 10-р цэцэрлэг, Баруунбаян-Улаан сумын Төрийн сан, ЗДТГ, ИТХ, ЕБС, Соёлын төв, Цэцэрлэг, ЭЭС, Есөнзүйл сумын Соёлын төв, Цэцэрлэг, Зүүнбаян-Улаан сумын ИТХ, Нарийнтээл сумын Баянтээг багийн Сургууль, Нарийнтээл сумын Төрийн сан, ЭЭС, Уянга сумын ИТХ, Хайрхандулаан сумын ЕБС, Хайрхандулаан сумын Соёлын төв, Бат-Өлзий сумын ЭЭСан

График-1 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд мэдээлсэн хэрэгжилтийн хувь



Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³-д заасны дагуу 244 байгууллагаас 13 байгууллагад төсөвт өөрчлөлт орсон тухай мэдээллээ бүрэн байршуулсан байна.

Хуулийн 6.4.2⁴-д хамаарах байгууллага байхгүй байна.

Хуулийн 6.4.3⁵-д нийт 244 байгууллагаас 78 мэдээллээ байршуулж, 158 байгууллага хамааралгүй, Зүүнбаян-Улаан сумын ЗДТГазар мэдээллээ байршуулаагүй байна.

Хүснэгт 4-Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5-д заасныг дараах хүснэгтээр харуулав.

6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	693
	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний мөнгөн дүн (сая. төг)	21545.0
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	1
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	51.8
6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	1547
	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний мөнгөн дүн (сая. төг)	30445.8
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	55
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	654.67
6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний тоо	3065
	5 сая төгрөгөөс дээш нийт гүйлгээний мөнгөн дүн (сая. төг)	82058.6
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний тоо	146
	Үүнээс: Мэдээлээгүй гүйлгээний мөнгөн дүн	2673.8

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁶-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг Богд сумын ЗДТГазар 51.8 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

³ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;

⁴ тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;

⁵ тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

⁶ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5⁷-д заасан Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 17 байгууллага 654.7 сая төгрөгийн 55 гүйлгээг мэдээлээгүй байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг 34 байгууллага 2673.8 сая төгрөгийн 146 гүйлгээг мэдээлээгүй байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ гэсэн цэс Арвайхээр сумын Төрийн сангийн шилэн дансны цахим хуудсанд байсан боловч аймаг болон бусад сумдын төрийн сангийн шилэн дансны цахим хуудсанд тухайн цэс байхгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6⁸, 6.4.7⁹-д заасан мэдээллийг байгууллагууд бүрэн байршуулсан байна. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу аймгийн хэмжээнд 1028.96 сая төгрөгийн 225 төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлсэн байна. Тус заалттай холбоотой мэдээллийг Арвайхээр сумын 1, 2-р сургууль Засгийн газрын 2016 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу бүрэн гүйцэд оруулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2¹⁰-д хамаарах Нисэх буудал ТӨҮГ, Өвөрхангай АЗЗА УТҮГ, Сум дундын ойн анги ТӨҮГ, Өвөрхангай аймгийн Авто тээврийн төв, Хархорин АЗЗА УТҮГ зэрэг байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдаж хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг бүрэн байршуулсан байна. Харин **Өв ЭКО Мийт ОНӨҮГазар** шилэн дансны цахим хуудсанд бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна.

А.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудаст бүртгэгдсэн 244 байгууллага Хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэсэн заалтыг бүрэн хангаж мэдээллийн самбарт бүрэн байршуулсан байна.



Дээрх байгууллагуудын мэдээллийн самбар нь олон нийт мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл мөн хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэх албан тушаалтны гарын үсгээр бүрэн баталгаажуулсан байдлаар мэдээлж хэвшсэн байна.

⁷ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

⁸ худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;

⁹ байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;

¹⁰ төрийн өмчит үйлдвэрийн газар;



А.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5¹¹-д заасан мэдээлэл нь тус аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүрэгт хамааралгүй болно.

БҮЛЭГ-Б

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байна.

Б.1. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа Баянтээг ХК нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3¹²-д хамаарах Баянтээг ХК нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг бүрэн байршуулсан байна.

Аймгийн Баянтээг ХК нь Засгийн газар, орон нутгийн өрийн бичиг, бусад санхүүгийн хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, Засгийн газар, орон нутгийн баталгаа, төсвийн өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаар мэдээлэл гараагүй байна. Мөн их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалтын шийдвэрийн мэдээлэл байхгүй байна.

Б.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна.

Тус аймагт хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан 53 аж ахуй нэгж байгууллага улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 58 төсөл арга хэмжээг гүйцэтгэснээс Арвайхээр Цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар, Билэгт манлай ХХК, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Биеийн тамир спортын газар, Боловсрол, соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Стандарт,

¹¹ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана:

¹² хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани;

хэмжил зүйн хэлтэс, Хархорин сумын Эрдэнэзуу музей өөрийн шилэн дансанд хөрөнгө оруулалтын мэдээллээ байршуулсан бусад аж ахуй нэгжүүд шилэн дансны цахим сайтын аж ахуй нэгж гэсэн цэсэнд бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна. (Маягт-4)

№	Аж ахуй нэгжийн нэр	Нийт төсөвт өртөг / сая.төг /	Өгсөн санхүүжилт
1	Алтай байдраг констракшн ХХК	951.6	248.2
2	Арвай Рөүд ХХК	35.6	35.6
3	Арвайхээр сумын ЗДТГазар	280.0	280.0
4	Ариунбилгүүн ХХК	73.5	73.5
5	Бага хөгшин ХХК	884.0	475.7
6	Бат-Угсралт констракшн ХХК	789.1	324.1
7	Баян дөхөмийн хурд ХХК	138.0	127.8
8	Богдын буян ХХК	29.5	29.5
9	Болор-Өрөг ХХК	30.0	29.3
10	Бургас Трейд ХХК	339.9	339.9
11	Бэлчир констракшн ХХК	97.7	65.4
12	Вентана ХХК	908.4	462.4
13	Ган нэгдэл ХХК	1748.9	1346.6
14	Ганцаг ХХК	50.0	47.2
15	Гүн чимэгтэй ХХК	99.9	93.7
16	Девсофт ХХК	123.3	108.6
17	Дуутын нуруу ХХК	47.9	44.7
18	Дүүрэнхорол ХХК	39.8	39.0
19	ДШЛ ХХК	949.9	949.9
20	Итгэлт-Өргөө ХХК	258.0	183.0
21	Лхагвабуд	77.0	77.0
22	Марал-Инж ХХК	82.4	51.9
23	Навтгар Хайрхан ХХК	837.1	534.5
24	Нутгийн буян групп ХХК	881.9	482.7
25	НЬЮКОНСТРАКШН ХХК	853.9	265.2
26	Оазислэнд Констракшн ХХК	368.7	258.1
27	ӨВ АЗЗА ТӨХК	711.7	683.2
28	Өв Од Барилга ХХК	44.0	41.2
29	ӨВМТХ ХХК	2,000.0	933.6
30	Өндөрсант Хайрхан ХХК	995.2	589.0
31	Сан ХХК	46.1	23.0
32	Сизу ХХК	58.2	40.0
33	Сод-Ээл ХХК	83.0	76.1
34	Тэд констракшн ХХК	2,750.1	1,299.2
35	Харшийн гэгээ ХХК	1,262.1	388.6
36	Химон констракшн ХХК	1,027.6	346.3
37	Чусан ХХК	97.5	92.5
38	Шашир констракшн ХХК	905.0	230.0
39	Эрхэс импекс ХХК	82.0	78.5
40	Эрч хүч хөгжил ХХК	657.8	322.1
41	Эс жи эм ХХК	46.9	43.4
42	Юу зэт эрдэнэ ХХК	72.5	67.8
		21815.7	12228.0

Нийт 42 аж ахуй нэгж 12228.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Б.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй бөгөөд мэдээллээ байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5¹³-д төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 4 байгууллага байгаагаас Оюуны-Ундраа бага сургууль мэдээллээ байршуулж, Лхавгабаасан цэцэрлэг,

¹³ төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.

Жаргалант ирээдүй мөрөөдөл цэцэрлэг, аймгийн Ахмадын хороо гэсэн 3 байгууллага шилэн дансны цахим хуудаст бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна.

БҮЛЭГ-В	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавьсан боловч сумдын ИТХурлын хяналт, өмнөх оны зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.
----------------	--

В.1. Сумдын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 65 хувьтай хяналт тавьсан байна.

Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны үйл ажиллагаанд 2018 онд хөндлөнгийн хяналт тавьсан тайлан ирүүлсэн сумд



☐ Аймгийн ИТХурал, Хархорин, Арвайхээр, Уянга, Төгрөг, Есөнзүйл, Гучин-Ус, Өлзийт, Сант, Тарагт, Хужирт, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий сумдын ИТХурал

Шилэн дансны үйл ажиллагаанд 2018 онд хөндлөнгийн хяналт тавьсан тайлан ирүүлээгүй сумд



☐ Богд, Хайрхандулаан, Баян-Өндөр, Бүрд, Нарийнтээл, Баруунбаян-Улаан, Баянгол сумдын ИТХурал

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газраас сумдад Шилэн дансны тухай хуулийн дагуу хяналт тавьсан ажлын баримтыг ирүүлэх тухай 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 180 дугаар албан тоот хүргүүлэхэд аймгийн ИТХурал, 12 сумдын ИТХурлаас Шилэн дансны цахим сайтад хяналт хийж ажлын тайлангаа ирүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 74 дүгээр тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ажлын хэсэг Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан байна. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт тавин улирал бүр тайланг нэгтгэлийн программаар гаргаж байна. Энэ тайлангаас харахад аймгийн хэмжээнд 3-р улирлын байдлаар нийт 206 байгууллага 22615 мэдээллийг цахим хуудсанд байршуулах ёстойгоос 21873 мэдээллийг байршуулсан нь хэрэгжилт 96.7%-тай байна. Харин 182 байгууллагын мэдээ илгээлт хянагдаж хуулийн хэрэгжилт 85.7%-тай байна гэж хяналт тавьсан байна.

Богд, Хайрхандулаан, Баян-Өндөр, Бүрд, Нарийнтээл, Зүүнбаян-Улаан, Баянгол сумдын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийг 8.1¹⁴-д заасан хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

В.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагч хяналтыг хэрэгжүүлсэн байна.

¹⁴ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагч Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн зүйлийн 8.2¹⁵-д заасны дагуу тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төсвийн байгууллагад шилэн дансны дотоод хяналтыг тавьж ажиллахад 2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 206 байгууллага 22615 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 21873 мэдээллийг байршуулж хуулийн хэрэгжилт 96.7 хувьтай байна.

В.3 Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудынхаа ажлыг дүгнэхдээ төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болгосон байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс ажил дүгнэхдээ сумдыг 11, агентлагийг 10 шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ үнэлгээ хийдэг байна. Үүнд: байгууллагын ил тод байдлын үнэлгээнд төсвийн ил тод байдал буюу шилэн дансны хуулийн хэрэгжилт, мэдээллийн самбараар мэдээллийг хүргэж байгаа байдал зэргийг хамруулан ажил дүгнэх шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс шилэн дансны сайтад байршуулсан мэдээллийг аймгийн Засаг даргын дэргэдэх 21 агентлагийг 79-96 хувиар, харин 19 сумыг 70-100 хувиар үнэлсэн байна.

В.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Өмнөх аудитаар Богд, Баян-Өндөр, Хайрхандулаан сумдын ИТХуралд Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийг 8.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэх тухай зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй тул Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “Хууль тогтоомж зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг хүргүүлж байна.

Өмнөх оны аудитаар мэдээллийн чанарт анхаарах талаар зөвлөмж өгөгдсөн боловч энэхүү зөрчил давтагдан гарсаар байна. Тухайлбал:

- Байгууллага, дарга, нягтлан бодогчийн мэдээллийг тухай бүрд нь шинэчлэхгүй байгаа нийтлэг алдаа байна.
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг оруулахдаа мөнгөн дүнг мянган төгрөгөөр бичдэг, сар бүр өссөн дүнгээр оруулахгүй байх, зөвхөн орж ирсэн санхүүжилтийн дүнг оруулах, тухайн сар бүрдээ мэдээллээ бүрэн оруулсан боловч улирал, хагас жил, жилийн эцсийн цэсэд төсвийн гүйцэтгэлийн мэдээг оруулахгүй байх.
- Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан гэх файл хавсаргах мэдээллүүдэд буруу файл, өөр байгууллагын мэдээллийг оруулах, хоосон файл оруулах гэх мэт алдаанууд мөн гарч байна.

¹⁵ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

ДҮГНЭЛТ.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд хуулийг 95.5 хувьтай хэрэгжүүлж, хуулийн 6.9, 8.1 дэх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Бүлэг А. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна.

А.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж, хуульд заасан мэдээллийг 95.5 хувьтай байршуулсан байна.

А.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн байршуулсан байна.

Бүлэг Б. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй, хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байна.

Б.1. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа Баянтээг ХК нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Б.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байна.

Б.3. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаагүй бөгөөд мэдээллээ байршуулаагүй байна.

Бүлэг В. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавьсан боловч сумдын ИТХурлын хяналт, өмнөх оны зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

В.1. Сумдын ИТХурал Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 65 хувьтай хяналт тавьсан байна.

В.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагч хяналтыг хэрэгжүүлсэн байна.

В.3 Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудынхаа ажлыг дүгнэхдээ төсвийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт болгосон байна.

В.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ.**Зөвлөмж: Аймгийн Засаг дарга Г.Ганболд-д**

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т хамаарах аж ахуйн нэгжүүдтэй арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээнд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх заалтыг тусгаж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах.

Зөвлөмж: Сүмдын ИТХ-ын дарга нарт

Хуульд заасны дагуу Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмж: Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Л.Хатанбаатар-т:

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2018 оны 11 сарын 29, өдөр

Дугаар А/21.

Арвайхээр

**Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”, 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлан /УАГ-НАГ/2018/01-НА/-г баталсугай.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгөгдсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн ИТХурлын дарга /А.Ишдорж/, аймгийн Засаг дарга /Г.Ганболд/, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2019 оны 3 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер /Д.Гансүх/-т даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Л.ЛАМААЧИН

450113

Өвөрхангай аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд
хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

Д/д	Зөрчил хариуцагчийн		Зөрчлийн товч утга
	Нэр	Албан тушаал	
1	Ш.Гүрдорж	Баян-Өндөр сумын ИТХурлын дарга	Шилэн дансы тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ." заасан хяналт хэрэгжүүлээгүй, тайлан ирүүлээгүй.
2	Ц.Баярмөнх	Богд сумын ИТХурлын дарга	
3	П.Алтанган	Хайрхандулаан сумын ИТХурлын дарга	